

ОРЧУУЛГА, НИЙТЛЭЛ, МЭДЭЭЛЭЛ

**МОНГОЛД ДАНДИНЫ «ЗОХИСТ АЯЛГУУНЫ ТОЛИЙГ»
СУДАЛЖ БАЙГАА НЬ****Лыгжима Халоупкова (БНСЧСУ)**

Орчин үеийн Монголд бусад орнууд, тухайлбал эртнээс уламжлалт өргөн харилцаатай байсан Энэтхэг, Төвдтэй шинжлэх ухаан, соёлын ба уран зохиолын талаар харилцаа холбоотой байсны түүхийг судлахад үлэмжхэн анхаарч байна.

Энэ өгүүлэлд Дандины «Кавъяадарша» (Зохист аялгууны толь) хэмээх яруу найргийн онолын шастир, түүний монголд дэлгэрсэн талаар бид анхаарлаа хандуулсан юм. «Зохист аялгууны толь» нэрээр алдаршсан МЭ VII зууны үеийн эртний энэтхэг зохиогчийн энэ бүтээл тэр үеийн яруу найргийн онолын шилдэг ололтыг багтаасны зэрэгцээ нэг ёсондоо Энэтхэг, Төвд, Балба, Монголын олон яруу найрагч, зохиолчдын шүлэг зохиох сурах бичиг болж байжээ. «Кавъяадарша» нь Энэтхэг 1942, 1952, 1959, 1963, 1964 онд англи хэлээр хэсэгчилсэн ба бүрнээр орчуулагдан хэвлэгджээ.¹ Дандины «Зохист аялгууны толийг» Төвд, Монголд маш тодорхой, ул үндэстэй судалж манай үеийг хүртэл түүнд олон тооны тайлбар хийж, яруу найргийн арга хэрэглүүрийг нь ашиглаж шинэ шинэ зохиол туурвисаар иржээ.

Сүүлийн үед БНМАУ-д утга зохиолын дурсгал болох уг шастир, монгол утга зохиолын хөгжилтөд түүний үзүүлсэн нөлөөг судлах сонирхол эрс өссөн байна. Энэ өгүүлэлдээ бид өнгөрсөн үеийн соёлын өвийн шилдэг ололтыг ирээдүйн үеийнхэнд дамжуулан үлдээхийн тулд их зүйл хийсэн ба хийж байгаа Ц. Дамдинсүрэн, Б. Ринчен, Ш. Бира, Ч. Алтангэрэл, Д. Ёндон нарын зэрэг орчин үеийн монголын эрдэмтдийн бүтээлийг ашиглав.

Үндэс, тайлбаруудыг гаргахад хүрсэн уламжлалын талаар эхлээд хэдэн үг дурдмаар байна. Эртний Энэтхэг, Төвд, Монголд аливаа ухааны гол сэдэв, үзэл санаа, хамгийн чухал нэр томьёо, ухагдахууныг тодруулан гаргасан хураангуй үндэслэлийг зохион гаргадаг сонирхолтой зуршил бий болсон байна. Хураангуй цэгцтэй, яруу сонсголонтой бөгөөд амар хялбар цээжлэхийг урьдал болгож тэдгээр үндсийг голцуу шүлгээр зохиодог байжээ. Тэдгээр үндсэн зохиолд янз бүрийн тайлбарыг бичгээр ба амаар үе үе нэмдэг байв. Олон жилийн турш аман тайлбаруудыг багш нь шавьдаа дамжуулж ирсэн байх ба бас ч бичгийн хувилбарт засвар, нэмэлт хийсээр байсан нь илүү давуу байжээ.

«Зохист аялгууны толь» нь тийм төрлийн утга зохиолд хамаарна. Түүний үндэс нь гурван бүлгээс бүрддэг. Дандины шүлэглэн бичсэн бичвэр юмаа. Шүлэг, үргэлжилсэн зохиолын хэлбэрээр болон нэгийг

¹ Дандины «Зохист аялгууны толь». Монголын дурсгалт бичгийн чуулган. т. XVIII. Ф. I. Улаанбаатар. 17-р тал.

нөгөөтэй нь хутган зохиож болдог. Яруу найргийн хэлний мөн чанарыг тодорхойлоход нэгдүгээр бүлгээ зориулжээ. Дандины яруу найргийн онолын их хэмжээтэй, чухал хэсэг болох аланкар буюу «чимгийн» тухай сургаалыг хоёрдугаар бүлэгт тайлбарлажээ. Уран сайхны яруу илэрхийллийн үүднээс яруу найрагт ашигладаг найруулгын элдэв арга хэрэглүүр нь «чимэг»-т хамаарна. Дотоод утга санаа, агуулгынх нь үүднээс эд юмсын сайхан чанарыг ухаарахад тус болох утгын гучин таван чимгийг «Зохист аялгууны толь»-д тодорхойлон өгүүлжээ. Үүнд: «төрөл бүрийн зэрэгцүүлэл, адилтгал (ирата), дүр, зүйрлэл (чирака), олон утгат үгс гээд ойролцоо утгат үгсийг² ашиглах нь чимэгт эн тэргүүнд хамаарагдана. Энэ шастирын гутгаар бүлэг нь гучин хоёр хэсэгтэй, гурван зуу хүртэл зүйлтэй үгийн буюу авианы (дууны, орч) чимэгт зориулагджээ. Шүлгийг гадаад авианых нь талаас чимж өгдөг бөгөөд яруу найргийн зохиол зохиоход зайлсхийгүүштэй (найруулгын орч.) гэрийн тухай сургаалаар энэ шастир төгсөж байна. Ер нь Дандины «Зохист аялгууны толь»-д яруу илэрхийллийн онц өвөрмөц, бэрхшээлтэй хэлбэрийг аар саар зүйл гэхээргүй эцэст нь хүртэл нарийн нягт боловсруулан ангилсан байдаг юм.

«Зохист аялгууны толийг» Төвд, Монголд XIII зуунаас эхлэн судалсаар иржээ. Нэрт хэлзүйч Саж бандид Гунгаажалцан (1182—1251) «Зохист аялгууны толь»-ийг анх удаа төвдөөр орчуулж үндсэн хэсэгт тайлбар хийжээ. 1258—1280 оны хооронд Энэтхэгийн бандид Шри Ланкшимакаратай хамтран төвдийн эрдэмтэн Шонтон Доржжалцан «Зохист аялгууны толь»-ийн бүрэн төвд орчуулгыг хийсэн байна.³ Төвдөөс Монголд Хубилай хааны залж ирүүлсэн алдарт номын багш Пагва лам Лодойжалцан энэхүү орчуулгыг сэдэн санаачилжээ. Тэрээр өөрөө «Дандины «Зохист аялгууны толь»-д өгүүлсэн шүлэг зохиох журам, яруу найргийн онолын дагуу захиа, айлтгал, магтаал зохиож байс Саж бандидтай хамт «Зохист аялгууны толь»-ийг хичээл зүтгэл гарган дэлгэрүүлэгч байсан юм»⁴ XIV зууны үеийн Монголын нэрт яруу найрагч Чойжи-Одсэр яруу найргийн ур чадварын нууцыг бас эзэмшиж байсан юм. Түүний зохиосон «Махагалын магтаал», «Бурхны арван хоёр зохионгуй» болон бусад зохиолд юмсын үндсэн шинж чанарыг илрүүлэн гаргах ихэсгэл, багасгал, зүйрлэл, адилтгал г.м. яруу найргийн арга хэрэглүүр олон гардаг. Түүнээс гадна Чойжи-Одсэр «дууны чимгийн» зарим хэлбэрийг ашигласан байдаг»⁵ Анхдугаар Богд Жавзандамбын (1635—1723) шавь гүүш Гэлэгжалцан XVIII зуунд энэ шастирыг монголоор орчуулж Данжурын 205 дугаар ботид оруулах хүртэл ба түүнээс хойш XVII—XVIII зууны үеэр түүнийг судлах эрмэлзэлтний тоо их олширчээ.

Ер төвд хэлт монголын утга зохиолын чиглэлийн төлөөлөгчид эл шастирыг төвд эхээр нь бүр эртнээс судалж байжээ. Тэдгээрийн зарим нь бүх агуулга буюу зарим бүлэгт тайлбар зохиож, бас зарим нь жижиг хэсгүүдийг сонгон аваад бие даасан яруу найргийн арга барилыг

² Баранников А. П. Изобразительные средства индийской поэзии. Ленинград, 19-17, стр. 12 (Баранников А. П. Энэтхэг яруу найргийн дүрслэлийн арга хэрэглүүр).

³ Дандины «Зохист аялгууны толь» Төвд, Монголд. БНМАУ дахь Энэтхэгийн судлал. УБ. 1979. 7-р тал (Англи хэлээр)

⁴ Бира Ш. Монгольская историография (XIII—XVII вв) Москва. 1978, стр. 87. (Монголын түүх бичлэг, XIII—XVII зуун)

⁵ Цэрэнсодном Д. XIV зууны үеийн яруу найрагч Чойжи-Одсэр. Улаанбаатар 1969, 119 —123-р тал,

шинжлэн судалж иржээ. Монголын утга зохиол судлагч Ч. Алтангэрэлийн бичсэнээр тэдгээр хүмүүсийн тоо хэдэн зууд хүрч байжээ.⁶

«Яруу илэрхийллийн гүнээс гүн далайн давалгаа саадыг туулан гатлах хүсэлтний хөлөг онгоц»⁷ гэж «Зохист аялгууны толийг» нэрлэсэн тавдугаар Далай лам Агваанлувсанжамцын зохиол нь «Зохист аялгууны толийн» шилдэг тайлбар юм. Цаашид бид нэрт монгол зохиогчдын нэр ус, тэдний бичсэн тайлбарыг өөрсдийн бололцооны хирээр дурдая: Зал бандид Лувсанпэрэнлэй (1642—1715) «Зохист аялгууны толийн» Монгол дахь анхны тайлбарыг «Утгын гучин таван чимгийн үлгэр» (1670 орч) нэртэйгээр зохиож түүндээ нийт 258 бадгийн 1033 шадаас бүрдэх хоёрдугаар бүлгийн уран яруу илтгэх хэлбэрийг тайлбарласан шүлэг зохиосон байна.⁸

Монголын нэрт түүхч, зохиолч, гүн ухаантан, эмч «тэр үедээ нэвтэрхий боловсорсон хүн» Сүмба Хамбо Ишбалжир (1704—1788) «Зохист аялгууны толийг» хараанаасаа гаргасангүй. Тэрээр маш чухал хоёр тайлбар зохиосны нэг нь эхлэн бичигч шүлэгч нарт зориулсан «Үгсийн чимгийг товчлон хураасан яруу аялгуунд орох хаалга»⁹ хэмээгдэх болой.

«Панчатантра», «Рамаана»-г монгол уншигчдад танилцуулсан нэрт зохиолч эрдэмтэн, дуун хөрвүүлэгч Цахар гэвш Лувсанцүлтэм (1740—1810) бас: «Зохист аялгууны толийн» үгийн чимэгт шинэ жишээ гаргаж хоёр тайлбар («Утгын чимгийн тийн агуулал», «Дууны чимгийн тийн агуулал») зохиожээ.

Алшаагийн Дандарлхаарамба (1759—1842) бол гүн ухаан, яруу найргийн гүн арвин мэдлэгтэй, төвд монгол хэл шинжлэлийн салбарт хийсэн бүтээлээрээ нэрд гарсан хүн байжээ. «Зохист аялгууны толийн» гутгаар бүлгийн жишээг өгүүлэх саруул оюунтны хоолойн чимэг үзэсгэлэнт сувдан эрхи» гэдэг зохиолыг Дандарлхаарамба зохиожээ.¹⁰ Дандарлхаарамба бол Дандины яруу найргийн арга барилыг ашиглаж олон магтаал бичжээ. Тухайлбал: үлгэрлэн адилтгах гучин хоёр чимгийн үүднээс өөрийн багш Лондол ламыг магтах магтаалын шүлгийг тэр зохиожээ. Энэ сэдвээр төвд зохиогчдын бичсэн бүтээлийг нарийн нягт судалж «Зохист аялгууны толь»-д нэг томоохон (374 хуудас) тайлбарыг Равжамба Агваантүвдэн (XVIII-зууны эцэс) зохиожээ. Санскритаас, төвд галигаар тохирох жишээг шигтгэж янз бүрийн домгийг ашиглаж энэ зохиолыг зохиогч үргэлжилсэн үгийн хэлбэрээр бичжээ. Тэрээр мөн шүлэг бичсэн юм. Жишээ нь: утгын гучин таван чимгийн зарчмаар бичсэн «Дарь эхийн магтаал»-даа ертөнцийн жирийн эмэгтэйн гоо сайхныг бурхны дүрээр алдаршуулан дуулсан буй.¹¹

Ханчин Хамбо Жамъянгаравын (1861—1919) «Зохист аялгууны толийн бэрхийг тайлсан тайлбар-Янжинч баясгах дуулал эгшиг» хэмээх зохиол нь хэмжээгээрээ их (560 гаруй хуудастай), ач холбогдлоороо чухал юм. Өмнөх үеийн тайлбаруудын дутагдлыг зохиогч илрүүлэн яруу найргийн чимгийг учир шалтгааны дэс дараалалтай нэгд нэгэнгүй

⁶Алтангэрэл Ч. Дандины Зохист аялгууны толийн монгол тайлбарын тухай. Олон улсын монголч эрдэмтний II их хурал. т. 1. Улаанбаатар. 1973, 43-р тал.

⁷Дандины «Зохист аялгууны толь» ... 9-р тал.

⁸Алтангэрэл Ч. Монгол зохиолчдын төвдөөр бичсэн бүтээл. Монголын уран зохиолын тойм. т. 2. Улаанбаатар. 1976. 607-р тал. Ш. Бира, Зая бандид Лувсанпэрэнлэй «Болор толь» (Англи хэлээр) «Акта Ориенталиа» гэдэг Унгарын Шинжлэх Ухааны Академийн сэтгүүл. 1980. т. XXXIV, ф. 1—3.

⁹Мөн ном 612-р тал.

¹⁰Мөн тэнд. 621-622-р тал.

¹¹Мөн тэнд. 628, 631-р тал.

тайлбарласан энэ зохиол нь гүн ухааны шастирын хэлбэртэй юм. Түүний зэрэгцээ зохиогч уран сайхны жишээг зохиохдоо Монгол улсын түүх, түүний эрх баригчдын материалаас иш татсан байна.¹²

Утга зохиол судлагч С. Лувсанвандангийн саналаар «монгол зохиогчдын бүтээлүүд тэдний тайлбарууд нь энэтхэг, төвдийн онолчдын зохиол бүтээлийн хуулга төдий байсангүй. Тэд өөрийн яруу найргийн онолыг бий болгож түүнээ өөрсдийн зохиол бүтээлдээ үлгэрлэн үзүүлэхийг эрмэлзэж байв. Иймээс «... дээр дурдсан улс түмний шүлэг зохиох онол, практикийн гарал үүсэл, хэв шинжийн үзэгдлийг харьцуулан судлах хэрэгтэй»¹³ юм.

XIX зууны үеийн Монголын шүлэгч, зохиолчдын бүтээлээс Дандины яруу найргийн чимгийн ая дуу сонсдож байна. Нэрт шүлэгч, зохиолч Д. Равжаа, гүн ухаантан Ш. Дамдин, Буриадын хэл шинжлэлч-орчуулагч Номтын Ринчин болон бусад хүмүүс өөрсдийн зохиол бүтээлдээ утгын ба дууны чимгийг ашиглаж байжээ. Тухайлбал «Зохист аялгууны толийн» зүйрлэлийн хорин арга хэрэглүүрийн дагуу бичигдсэн «Эгшигт охин тэнгэрийн дуулал» болон мөн адилтгалын гучин хоёр чимгийн дагуу бичигдсэн «Гандан хийдийн дууллыг» Ш. Дамдин зохиожээ.¹⁴

Орчин үеийн Монголд эртний уран бүтээлийн шилдэг уламжлалыг хөгжүүлэх ажил үргэлжилсээр байна. Хувьсгалч яруу найрагчдын нэг С. Буяннэмэх бол төвд, хятад, манж хэл сайн мэддэг хүн байсан бөгөөд ил ба далд утгатай шүлгүүдийн тухай сэдэв гаргахдаа аланкарын онолыг мэддэг байжээ.¹⁵ Мөн «Д. Нацагдорж, Б. Ринчен, Ц. Дамдинсүрэн, Ч. Лхамсүрэн, Ж. Бадраа зэрэг яруу найрагчдын зохиол бүтээлд яруу найргийн чимгийн олон жишээ гардаг»¹⁶ байна. Тухайлбал Б. Ринчен «Гүнж» өгүүллэгийн оршлын шүлгээ дууны чимгээр бичжээ. Шүлгийг янз бүрийн чиглэлд уншихад утга санаа нь тодрох, үгийн байрлал нь нарийн тодорхой эмх журамтай маш өвөрмөц чанарыг баримталсан Самандбадраагийн хүрдийн үндсэн дээр эрдэмтэн лам Иштавхай «Энх тайвны олзийг бадруулагч»¹⁷ хэмээх үгийн сүлжээг зохиожээ.

Лениний мэндэлсний 100 жилийн ойд зориулж судлагч Х.Гаадан эдгээр хэрэглүүрийг ашиглан шүлэг бичжээ. Адилтгалын хорин найм дахь хувилбартай дүйх арга барил Ц. Дамдинсүрэн, Д. Цэвэгмид нарын шүлэгт гардгийг монголын яруу найраг судлаач Д. Цэдэв дурдсан байдаг. Ийнхүү монголын зохиогчдын олон шүлэг нь Дандины «Зохист аялгууны толь»-ийн адилтгалын жишээтэй тохирч байна¹⁸ гэж Д. Цэдэв үзжээ. Бичгийн ба аман уламжлалын адилтгалд хэрэглэгддэг олон тооны холбоо үгсээс (тэдгээр нь «Кавъяадарша»-д нийтдээ 74 бий. Л. Х) одоо үед зөвхөн дөрөв, тавыг хэрэглэж байна гэж Д. Цэдэв бичжээ.¹⁹

Дандины яруу найргийн арга барилыг судлахад судлаач Х. Гаадан их анхаарал тавьжээ. Төвд хэлээр байгаа сурвалж бичигт тулгуурлан

¹² Д. Цэдэв Монгол яруу найргийн уламжлал шинэлэл. т. 1. Улаанбаатар 1973. 17-р тал.

¹³ С. Лувсанвандан. Об изучений литературного наследия монголов. Монголын судлал. (Studia Mongolica) т. VII, Fasc I Улаанбаатар. 1971. стр 16

¹⁴ Ш. Бира. «О золотой книге Ш. Дамдина» Улаанбаатар. 1964, стр 95.

¹⁵ С. Лувсанвандан. Монгольская поэзия. Хэл зохиол судлал. т. 11. Улаанбаатар. 1972, стр. 117

¹⁶ Х. Гаадан, Утгын гучин таван чимэг Шинжлэх ухаан амьдрал Улаанбаатар. 1975. № 1. 79-р тал.

¹⁷ Дандины «Зохист аялгууны толь»... 15-р тал.

¹⁸ Д. Цэдэв. Монгол яруу найргийн уламжлал шинэчлэл. т. 1. Улаанбаатар 90-р тал.

¹⁹ Мөн тэнд. 90-р тал.

Х. Гаадан чимэг бүрийн нарийн утга учир, түүний дотоод ангилал, хэллэг илэрхийлийн арга барил, тэдгээрийн бусдаас ялгарах онцлогийг тодруулан гаргажээ. Танин мэдэхүй, хувьчилсан ба субъектив үнэлгээний зэрэг өлмийн үндсэн гурван зорилт тэдгээрт хэрхэн илэрдгийг Х. Гаадан бодит жишээгээр гаргажээ. Бүх утгын чимгийг Х. Гаадан товч тайлбарлаад шалтгаан заах чимэг гийгүүлэгч чимэг, хураах ба гүтгэх чимгийн тухай дэлгэрэнгүй авч үзэн²⁰ «Дандины зохист аялгууны толийн» хуучин монгол эхийг хэвлүүлэхэд оршил бичжээ. Монголын яруу найргийн ухаанд хамгийн их нөлөө үзүүлсэн гэмээр адилтгал, зүйрлэл нь түүний тусгайлсан судалгааны гол зүйл юм. Дандины ном, монголын хуучин утга зохиолын хоорондын хэлхээ холбооны асуудлыг Х. Гаадан авч үзээд монголын зохиогчдын хувьд: 1. «Кавьяадарша» бол төвдөөр ном зохиоход үндсэн удирдлага болж байсан; 2. Зарим зохиогчид хэдийгээр төвд хэл мэдэж байсан ч гэсэн монголоор шүлэг зохиоходоо «Кавьяадарша»-гийн арга барилыг ашиглаж байжээ²¹ гэсэн дүгнэлт хийжээ.

Монголын эрдэмтэн Дандины найруулгын арга барилыг шууд судалсны зэрэгцээ Дандины судрын Монгол дахь судалгааны түүхийг онцгой анхаарсан байдаг. Энэ талаар академич Ш. Бира маргаангүй их гавьяа байгуулсан бөгөөд тэрээр сүүлийн үед энэ талын судалгааг удирдахын зэрэгцээ Дандины «Кавьяадарша»-гийн төвд, монгол тайлбар, бас төвд, монголд түүнийг орчуулсан ба дэлгэрсэн түүхийн талаар хэд хэдэн дорвитой илтгэл, өгүүлэл бичжээ.²² Ш. Бира төвд, монгол, англи орчуулгуудыг санскрит эхтэй нь харьцуулж Гэлэгжалцангийн монгол орчуулга үгчилсэн орчуулга хирнээ өөрийн ололт дутагдалтай байдаг ба Шондон Доржжалцан, Лакшимакара нарын дээр үеийн төвд орчуулга Ш. Бирагийн саналаар бол ур чадвар, үнэн зөв хийгдсэнээрээ давуу болсон «Зохист аялгууны толийн» шилдэг орчуулгын нэг юм гэсэн дүгнэлт хийжээ. Одоо академич Ш. Бира нөхдийн хамт санскрит эх, төвд, монгол, тайлбаруудыг ашиглан Дандины «Зохист аялгууны толийг» 1982 онд орчин үеийн монгол хэлээр бүрэн орчуулан гаргав. Энэ нь эл бэрх зорилтыг шийдвэрлэсэн орчин үеийн монгол хэл бичгийн эрдэмтдийн ур чадвар болон манай үед уул зохиолыг үнэхээр их сонирхож байгааг дахин нотлон харуулж байна.

Академич Ц. Дамдинсүрэн энэ судалгааны эхлэлийг тавьж «нийт хүн төрөлхтний соёл ухаанд, одоогийн бидний утга зохиол судлалд

²⁰Х. Гаадан. Утгын гучин таван чимэг. Шинжлэх ухаан амьдрал. Улаанбаатар. 1975. № 1. Шалтгаан заах чимэг. Хэл зохиол судлал. т. X. Fasc 6 УБ. 1975. Гийгүүлэгч чимэг, Хэл зохиол судлал. т. VIII Fasc 5, УБ., 1970. Дандины «Зохист аялгууны толийн» хураах ба гүтгэх чимэг. Дорнодахины судлалын асуудал. УБ., 1979. № 2.

²¹Х. Гаадан. Упамы и рубакы в «Кавьяадарше» (Зохист аялгууны толин дахь адилтгал, зүйрлэл). Диссертацийн хураангуй. УБ., 1976. 13-р тал.

²²Ш. Бира. Монгольские комментарии к «Кавьяадарше» Дандина. Доклады Монгольской делегации на XXVI конгрессе востоковедов в Дели. Улан-Батор. 1963.

Дандины «Зохист аялгууны толийг төвдөөр орчуулсан Лакшимакара, Шондон Доржжалцантай холбогдох хоёр захиа. Монголын судлал (Studia Mongolica) т. VII Fasc 4. УБ., 1970. Дандины «Зохист аялгууны толийн» Монгол тайлбарууд. БНМАУ-ын түүх, соёл, түүх бичлэгийн асуудлууд. Улаанбаатар, 1977. Дандины «Зохист аялгууны толийн» нэгдүгээр бүлгийн монгол орчуулга, санскрит эх, төвд орчуулга болон товч тайлбарын хамт. Studia Mongolia т. VI, Fasc 8, УБ. 1980, «Кавьяадарша» Дандина в Монголии-Литературные связи Монголии, Москва. 1981. Ш. Бира. Х. Гаадан, О. Сүхбаатар, Дандины «Зохист аялгууны толь» Шинэчилсэн монгол орчуулга, тайлбарын хамт. Corpus Scriptorum Mongolorum цувралаар т. XX. Fasc IV УБ., 1982.

нэмэр хандив болж байгаа»²³ «Зохист аялгууны толийн» тухай өөрийн өгүүлэлдээ түүнд өөрт нь мэдэгдэж буй 17 тайлбарын талаар мэдээлж утгын зарим чимгийг тайлбарлажээ. Ц. Дамдинсүрэн төвд зохиогчдын шүлгээс орчуулан эрдэмтдийн намтрыг судалж, яруу найргийг судалсан юм.

Академич Б. Ринчен Энэтхэгийн яруу найргийн өвөрмөц шинж, монгол газарт түүний хувьсан өөрчлөгдсөнийг судалжээ. Монгол Ганжурын катологийг хэвлэлд бэлтгэхдээ Б. Ринчен түүнд байгаа шүлгийн онолтой холбогдсон нэр томъёог судалсан байна. Тэрээр 1972 онд «Зохист аялгууны толийн» хуучин монгол орчуулгыг «Монголын дурсгал бичгийн чуулган» хэмээх эх бичиг судлалын цувралаар нийтлүүлжээ.

Мөн төвдөч Ч. Алтангэрэл Дандины номын их нөлөөг шингээсэн монголын төвд хэлт зохиогчдын бүтээлийг нэн хичээнгүйлэн судалжээ.²⁴ Жишээлэхэд XIX зууны үеийн Монгол шүлэгч Ишданзанванжилын төвд хэлээр зохиосон 150 гаруй зохиолын гарчгийг тэрээр орчуулж хэвлүүлсэн юм. Ишданзанванжилийн зохиолын зөвхөн нэрээс үзсэн ч гэсэн «авианы» (дууны. орч) ба «утгын» чимгийн аргыг уул шүлэгч өргөн дэлгэр ашиглаж байжээ гэж Ч. Алтангэрэл цохон заасан байдаг.²⁵ Ч. Алтангэрэл Олон улсын монголч эрдэмтдийн II их хуралд зориулж Дандины «Зохист аялгууны толийн» монгол тайлбаруудын тухай» гэсэн илтгэл бэлтгэсэн байна.

Монголын утга зохиол, ялангуяа уран зохиолд Дандины энэ ном их нөлөө үзүүлснийг эцэст нь тэмдэглэвэл зохилтой. Монголын олон шүлэгч, утга зохиол судлаачид шүлгийн онолын олон үеийн уламжлалыг тэдгээрийн эртний үндэс, тайлбарын үндсэн дээр судлахдаа бусад бүтээлүүдийн дотроос «Зохист аялгууны толь»-той танилцсан байна. Монгол зохиогчид Дандины яруу найргийн найруулгын гоо сайханд урамшиж, чимгийн тухай түүний сургаалыг бүтээлчээр эзэмшин мөн тэр хэмжээгээр өөрийн утга зохиолын яруу илэрхийллийн хэрэглүүрийг баяжуулсаар иржээ. «Зохист аялгууны толийг» судалсны үрээр буй болсон олон тооны тайлбар; бие даасан бүтээлүүд нь утга зохиол судлалын онолын ач холбогдолтой юм. Энэ нь монгол, энэтхэгийн утга зохиолын хоорондын хэлхээ холбооны тод жишээ мөн.

Чехословакийн Шинжлэх Ухааны Академиас гаргадаг „Archiv Orientalni“ гэдэг Ази, Африк, Латин Америкийн судлалын сэтгүүлээс (№ 4/50, 1982) товчлон орчуулсан

О. СҮХБААТАР

²³ Ц. Дамдинсүрэн. Дандины «Зохист аялгууны толь» ба түүний тайлбаруудын тухай товч мэдээ. *Studia Mongolica*, т. IV, Fasc 1, Уланабаатар. 1962. 24-р тал.

²⁴ Ч. Алтангэрэл. Монгол зохиолчдын төвдөөр бичсэн бүтээл т. 1, УБ., Монгол зохиолчдын төвдөөр бичсэн зохиолын онол. Монгол уран зохиолын тойм. т. II. УБ.. 1977.

²⁵ Ч. Алтангэрэл. Шинээр олдсон нэгэн гарчгийн тухай. Монголын судлал, (*Studia Mongolica*), т. VII, Fasc 5 УБ., 1970.